



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/568

Номгон

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд хаягийн  
өөрчлөлт хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ганга тун” 3126382 регистртэй ХХК-ний “Ганга тун” ЭСХ-12/02/026 дугаартай хоёрдугаар зэрэглэлийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийн хаягийг Баянхонгор сумын Дуурсах 3 дугаар багийн “Гийх наран” 1 дүгээр гудамжны 131 тоотод, “Оточ лхам” ХХК-ний 3131653 регистртэй “ЭСХ-12/02/026 дугаартай хоёрдугаар зэрэглэлийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийн хаягийг Баянхонгор сумын Рашаант 10 дугаар багийн 114-1-2 тоотод тус тус шилжүүлсүгэй.

2.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд хаягийн өөрчлөлт оруулсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг мөрдүүлэхэд удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601710321